

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Агуулга**

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3. Менежментийн захидал .....	11
4. Аудитлагдсан санхүүгийн тайлан.....	11
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН  
ЗАХИРАЛ Д.ОТГОНСҮРЭН ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/223  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дугаар зүйлд заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Чойжин ламын сүм музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чойжин ламын сүм музейн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Чойжин ламын сүм музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Чойжин ламын сүм музейн Захирал Д.Отгонсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойжин ламын сүм музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, ахлах аудитор О.Цэндхүү чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, аудиторын туслах М.Сэржмядаг, Д.Эрдэнэбаяр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Чойжин ламын сүм музей нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Чойжин ламын сүм музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Чойжин ламын сүм музей нь "Музейд хадгалагдаж буй монголын түүх, шашин, соёл, уран барилга, урлахуйн ухааны дахин давтагдашгүй үнэт бүтээлийг судлан сурталчилж, сэргээн баяжуулах, хадгалан, хамгаалж, хойч үеийнхэнд уламжлуулахад оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Музей нь нийт 6 сүмд монголын түүх шашны холбогдолтой 6385 гаруй үзмэр, эд зүйлсийг дэлгэн үзүүлдэг ба жилд дунджаар 15,000 гаруй үзэгч үйлчлүүлэгчдийг хүлээн авдаг, 20 ажилтантай, эрдэм шинжилгээ-сан хөмрөгийн нэгж, захиргаа-аж ахуйн нэгж гэсэн 2 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

2009 онд батлагдсан Улс, орон нутгийн музейн дүрмийн 1.2-д зааснаар Чойжин ламын сүм музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Музей, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа
- Музей нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, сургах, таашаал хүртээх зорилгоор хүн түүний орчинтой холбоотой бодит ба бодит бус байгаль, соёлын өвийг

цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, харилцан холбох байнгын үйл ажиллагаа бүхий ашгийн төлөө бус, олон нийтэд нээлттэй байгууллага байх

Чойжин ламын сүм музейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Чойжин ламын сүм музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Соёлын тухай
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Нийгмийн даатгалын тухай хуулинд ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 1 хувиар нэмэгдүүлсэн. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулинд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус музейн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Чойжин ламын сүм музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Чойжин ламын сүм музей санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS 3.0” програм хангамж ашигладаг байна.

Чойжин ламын сүм музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Чойжин ламын сүм музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 26 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 22 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус музей нь төрийн үйлчилгээ үзүүлэх зорилготой байгууллага тул нийт зардал нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх хамгийн тохиромжтой үзүүлэлт гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Чойжин ламын сүм музейн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 354,433.2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 7,088.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь музейн үйл ажиллагааны цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ, эрсдэл бага байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 23 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 17 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад 2 асуудалд санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	863.7	
2	Албан шаардлага өгсөн	1	647,600.0	
	Дүн	4	648,463.7	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Засгийн газрын 2016 оны 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 20000 м2 газрыг 647,600.0 мянган төгрөгөөр дахин үнэлсэн боловч газрын гэрчилгээ сунгагдаагүй шалтгаанаар санхүүгийн тайланд газрыг тусгаагүй байна.

Гэрчилгээ сунгагдаагүй шалтгаан нь Сити төв 199 м2, Ар монгол трейвел ХХК 227.4 м2 газрыг зөвшөөрөлгүй эзэмшиж байгааг шийдвэрлүүлэхээр 2015 оноос хойш хуулийн байгууллад хандсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Энэ нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол Улсын Засгийн газрын “Хамгаалалтын бүс тогтоох тухай” 2001 оны 96 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.”бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага хүргүүлэх

2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Чойжин ламын сүм музей болон Чоно ХХК-ийн хооронд 2007 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр Чойжин ламын сүм музейн 800 м2 газрыг тус компани үнэ төлбөргүй ашиглаж байгаа нь, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам"-ыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага хүргүүлэх

## **2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны сайдын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/648 тоот тушаалаар Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх комиссыг томилон 2018 оны 11 дүгээр сарын 01-нээс эхлэн 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдөр дуусгахаар заасан байна. Чойжин ламын сүм музейд 2018 оны жилийн эцсийн байдлаар 1002 дэсийн 6385 ширхэг 3,947,692.9 мянган төгрөгийн үзмэр хадгалагдаж байна. Музейн тооллогын комисс 2018 оны 12 сарын 11-ны өдрөөс эхлэн ажиллаж 2019 оны 02 сарын 13-ны өдрийн байдлаар түүх соёлын дурсгалт зүйлээс 194 дэсийн 233 ширхэг 1,589,533.0 мянган төгрөгийн үзмэр тоолж тооллогын ажлын явц 3.65 хувьтай байна. Улсын тооллогын явц хангалтгүй байгаа нь тус музейн барилгууд төвийн дулааны системд холбогдоогүй, үзмэрүүдийн 73 хувь нь үзүүлэлийн танхим болох 6 сүмийн байшинд, 27 хувь нь сан хөмрөгийн хүйтэн байранд хадгалагдаж байгаа бөгөөд тооллого хийхэд үзмэрүүдийг дулаан газарт зөөж байршуулах боломжгүй, хүйтэн орчинд тооллого явагдаж байгаагаас зургийн аппарат, компьютер царцаж, хөлдөх, унтрах, ажилчид даарах, үзмэрийн шилэн хорго хагарах зэрэг хүндрэлүүд байгаагаас тооллого хугацаандаа дуусахгүй байх эрсдэл өндөр байна.

Тус музей нь 20000 м2 бүхий 647,600.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газрыг гэрчилгээ сунгагдаагүй шалтгаанаар санхүүгийн тайланд тусгаагүй. Гэрчилгээ сунгагдаагүй шалтгаан нь Чоно ХХК 800 м2, Сити төв 199 м2, Ар монгол трейвел ХХК 227.4 м2 газрыг зөвшөөрөлгүй эзэмшиж байгаагаас шүүхэд маргаантай байна.

## **2.10. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Чойжин ламын сүм музейн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 331,569.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт 330,138.4 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого төвлөрүүлж, 324,226.5 мянган төгрөгийн зарцуулалт гаргаж, 5,911.9 мянган төгрөгийг жилийн эцэст буцаан төвлөрүүлсэн.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Чойжин ламын сүм музей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулахад нийт 3 ангилал бүхий 20 төрлийн 149 мэдээлэл оруулахаас 148 мэдээллийг иж бүрэн байршуулсан. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг шилэн дансанд байршуулаагүй. Мөнгөн хөрөнгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг бүрэн байршуулсан эсэхийг шалгахад 15 удаагийн гүйлгээгээр 287,359.3 мянган төгрөгийн орлогын, 5 удаагийн гүйлгээгээр 69,099.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг бүрэн байршуулсан байна.

## **2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай биелэгдсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Чойжин ламын сүм музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Чойжин ламын сүм музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Чойжин ламын сүм музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Балансын данстай холбоотой асуудал

##### 3.1.1 Илрүүлэлт:

Соёлын өвийн төвөөс 2017 онд 9 ширхэг түүх соёлын дурсгалт зүйл хүлээн авсан байна. Үүнийг түүх соёлын дурсгалт зүйлээр бүртгэхдээ үнэлгээ хийлгээгүй, үнэгүйгээр бүртгэсэн байна.

Энэ нь “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Сан хөмрөгийг үнэлж бүртгэлд тусгаагүй байх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үнэ төлбөргүй хүлээн авсан 9 ширхэг түүх соёлын дурсгалт зүйлийг үнэлж бүртгэлд тусгах

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Шинээр шилжүүлэн авсан 9 ширхэг танка зургийн үнийн саналыг боловсруулж, үнийг зохих данс бүртгэлд тусгах болно.

#### 3.2 Зардлын данстай холбоотой асуудал

##### 3.2.1 Илрүүлэлт:

Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварыг 11 ажилтан, албан хаагчдаас 188.3 мянган төгрөг дутуу суутган авч тус дүнгээр гарт олгох цалинг илүү олгосон.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан “орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

2018 онд өөрчлөгдсөн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх, татварын тооцооллыг буруу хийсэн байх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөгдөх татварын хэмжээг үнэн зөв тооцож байх

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

## 3.3 Балансын данстай холбоотой асуудал

### 3.3.1 Илрүүлэлт:

Татварын цахим системд тусгагдсан “Татварын тодорхойлолт”-д тайлант оны эцэст 675.4 мянган төгрөгийн өр төлбөр тусгагдсан байхад санхүүгийн тайланд өр төлбөр тусгагдаагүй байна.

Энэ нь “бодитой оршин байх ба тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

### 3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өрийн үлдэгдэл нь татварын албанаас гаргасан татварын тодорхойлолтоос зөрүүтэй байх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдэж зөрүүг залруулах

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>38,778,928.00</u></b>	<b><u>54,518,241.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,750,000.00	19,534,462.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	89,833.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,750,000.00	19,444,629.00
3351	Байгууллагаас авах авлага	2,750,000.00	19,444,629.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,028,928.00	34,983,779.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	36,028,928.00	34,983,779.00
35410	Бичиг хэргийн материал	7,184,559.00	7,837,150.00
35420	Аж ахуйн материал	11,810,658.00	12,409,468.00
35430	Сэлбэг хэрэгсэл	275,000.00	275,000.00
35470	Бусад хангамжийн материал	16,758,711.00	14,462,161.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,029,023,583.21</u></b>	<b><u>4,030,937,947.93</u></b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,029,023,583.21	4,030,937,947.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,029,023,583.21	4,030,937,947.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	47,281,000.00	27,462,751.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(20,308,027.12)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	208,476,804.33	230,694,654.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(178,859,810.64)	(198,424,489.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,325,779.00	73,343,679.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,469,041.36)	(51,715,526.64)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,947,692,959.00	3,947,692,959.00
39217	Ном	1,883,920.00	1,883,920.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Програм хангамж	990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(990,000.00)	(990,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,067,802,511.21</u></b>	<b><u>4,085,456,188.93</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	=	=
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,067,802,511.21</u></b>	<b><u>4,085,456,188.93</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,067,802,511.21	4,085,456,188.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,258,814,021.00	1,258,814,021.00
51101	Өмч: - төрийн	1,258,814,021.00	1,258,814,021.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	272,787,468.21	280,524,417.59
51210	Өмнөх үеийн үр дүн	272,787,468.21	272,787,468.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	7,736,949.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,536,201,022.00	2,546,117,750.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,067,802,511.21</u></b>	<b><u>4,085,456,188.93</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>313,283,559.95</b>	<b>373,517,350.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>83,810,889.85</b>	<b>80,758,050.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	83,810,889.85	80,758,050.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	83,810,889.85	80,758,050.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	77,221,000.10	79,316,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,389,889.75	1,441,550.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>229,472,670.10</b>	<b>292,759,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	205,084,700.00	231,353,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	205,084,700.00	231,353,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,169,200.10	61,405,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	25,380,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,169,200.10	36,025,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,218,770.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,218,770.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>337,819,627.50</b>	<b>358,011,466.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>337,819,627.50</b>	<b>358,011,466.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	324,662,417.50	352,099,567.44
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	150,700,031.00	153,031,682.00
210101	Үндсэн цалин	140,491,237.00	132,598,687.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,348,900.00
210104	Урамшуулал	10,208,794.00	11,084,095.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,284,539.00	18,326,003.00
210201	Тэтгэврийн даатгал	17,284,539.00	12,217,333.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,527,168.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,221,734.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	305,434.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,054,334.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,224,090.00	10,924,383.00
210301	Гэрэл, цахилгаан	18,783,180.00	9,630,000.00
210303	Цэвэр, бохир ус	440,910.00	1,294,383.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,866,633.00	9,315,400.00
210401	Бичиг хэрэг	339,800.00	786,400.00
210402	Тээвэр, шатахуун	131,800.00	2,992,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	662,733.00	2,346,874.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,445,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,286,500.00	3,189,226.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,195,500.00	5,041,900.00
210604	Урсгал засвар	6,195,500.00	5,032,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,503,900.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,503,900.00	2,000,000.00

Чойжин ламын сүм музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	48,020,371.00	63,515,421.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,402,471.00	58,715,021.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	2,399,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,089,000.00	640,400.00
210807	Газрын төлбөр	1,703,200.00	1,760,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	225,700.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	77,867,353.50	89,944,778.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,826,358.10	64,875,599.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,040,995.40	25,069,179.44
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,157,210.00	5,911,899.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,157,210.00	5,911,899.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,157,210.00	5,911,899.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(24,536,067.55)</u></b>	<b><u>15,505,883.56</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	7,768,934.18
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	7,768,934.18
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(7,768,934.18)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(24,536,067.55)</u></b>	<b><u>7,736,949.38</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>309,445,670.20</u></b>	<b><u>372,075,800.00</u></b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>79,973,000.10</b>	<b>79,316,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	79,973,000.10	79,316,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	78,421,000.10	79,316,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	77,221,000.10	79,316,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	-
120009	Бусад орлого	1,552,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>229,472,670.10</b>	<b>292,759,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	205,084,700.00	231,353,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	205,084,700.00	231,353,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,169,200.10	61,405,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	25,380,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,169,200.10	36,025,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,218,770.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,218,770.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>301,277,670.10</u></b>	<b><u>348,681,600.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>301,277,670.10</b>	<b>348,681,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>288,120,460.10</b>	<b>342,769,701.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	151,061,464.00	153,121,514.00
210101	Үндсэн цалин	128,625,970.00	132,688,519.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,226,700.00	9,348,900.00
210104	Урамшуулал	10,208,794.00	11,084,095.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,923,106.00	18,326,004.00
210201	Тэтгэврийн даатгал	16,923,106.00	12,217,334.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,527,168.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,221,734.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	305,434.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,054,334.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,224,090.00	10,924,383.00
210301	Гэрэл, цахилгаан	18,783,180.00	9,630,000.00
210303	Цэвэр, бохир ус	440,910.00	1,294,383.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,513,600.00	10,545,900.00
210401	Бичиг хэрэг	986,767.00	1,266,900.00
210402	Тээвэр, шатахуун	131,800.00	2,992,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	662,733.00	2,346,874.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,445,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,286,500.00	3,939,226.00

Чойжин ламын сүм музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	3,637,700.00	7,260,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,637,700.00	7,260,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,445,500.00	5,041,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00	-
210604	Урсгал засвар	10,195,500.00	5,041,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,503,900.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,503,900.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	58,089,900.00	99,524,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,230,000.00	91,594,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	2,399,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,089,000.00	750,000.00
210807	Газрын төлбөр	1,703,200.00	1,760,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,467,700.00	3,020,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,721,200.10	36,025,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,721,200.10	36,025,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,157,210.00</b>	<b>5,911,899.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,157,210.00	5,911,899.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,157,210.00	5,911,899.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>8,168,000.10</u></b>	<b><u>23,394,200.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,168,000.10</b>	<b>23,394,200.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,168,000.10</b>	<b>23,394,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	8,168,000.10	23,394,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,168,000.10	23,394,200.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(8,168,000.10)</u></b>	<b><u>(23,394,200.00)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
14	Бусад эх үүсвэр	-	-
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-
<b>24</b>	<b>ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР</b>	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл</b>	1,258,814,021.00	2,536,201,022.00	297,323,535.76	4,092,338,578.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(24,536,067.55)	(24,536,067.55)
<b>2017 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл</b>	<b>1,258,814,021.00</b>	<b>2,536,201,022.00</b>	<b>272,787,468.21</b>	<b>4,067,802,511.21</b>
<b>2017 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл</b>	<b>1,258,814,021.00</b>	<b>2,536,201,022.00</b>	<b>272,787,468.21</b>	<b>4,067,802,511.21</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,258,814,021.00</b>	<b>2,536,201,022.00</b>	<b>272,787,468.21</b>	<b>4,067,802,511.21</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	9,916,728.34	-	9,916,728.34
Тайлант үеийн үр дүн	-	-	7,736,949.38	7,736,949.38
<b>2018 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл</b>	<b>1,258,814,021.00</b>	<b>2,546,117,750.34</b>	<b>280,524,417.59</b>	<b>4,085,456,188.93</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	270,163,800.00	268,732,901.00	1,430,899.00	0.99
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	270,163,800.00	268,732,901.00	1,430,899.00	0.99
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	270,163,800.00	268,732,901.00	1,430,899.00	0.99
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	143,423,500.00	142,777,819.00	645,681.00	1.00
Үндсэн цалин	133,334,200.00	132,688,519.00	645,681.00	1.00
Унаа хоолны хөнгөлөлт	9,348,900.00	9,348,900.00	-	1.00
Урамшуулал	740,400.00	740,400.00	-	1.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,210,800.00	17,084,699.00	126,101.00	0.99
Тэтгэврийн даатгал	11,491,100.00	11,389,797.00	101,303.00	0.99
Тэтгэмжийн даатгал	1,429,900.00	1,423,726.00	6,174.00	1.00
ҮОМШӨ-ний даатгал	1,144,000.00	1,138,980.00	5,020.00	1.00
Ажилгүйдлийн даатгал	286,000.00	284,746.00	1,254.00	1.00
Эрүүл мэндийн даатгал	2,859,800.00	2,847,450.00	12,350.00	1.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,553,300.00	10,924,383.00	628,917.00	0.95
Гэрэл, цахилгаан	10,888,800.00	9,630,000.00	1,258,800.00	0.88
Түлш, халаалт	-	-	-	-
Цэвэр, бохир ус	664,500.00	1,294,383.00	(629,883.00)	1.95
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,617,100.00	9,617,100.00	-	1.00
Бичиг хэрэг	971,900.00	1,266,900.00	(295,000.00)	1.30
Тээвэр, шатахуун	2,992,900.00	2,992,900.00	-	1.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,548,200.00	2,346,874.00	201,326.00	0.92
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,442,400.00	-	1,442,400.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,661,700.00	3,010,426.00	(1,348,726.00)	1.81
<b>Норматив зардал</b>	4,500,000.00	4,500,000.00	-	1.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	4,500,000.00	-	1.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,268,900.00	12,268,900.00	-	1.00
Багаж, техник, хэрэгсэл	10,300,000.00	7,227,000.00	3,073,000.00	0.70
Урсгал засвар	1,968,900.00	5,041,900.00	(3,073,000.00)	2.56
<b>Томилолт, зочны зардал</b>	2,000,000.00	2,000,000.00	-	1.00
Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00	-	1.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	69,590,200.00	69,560,000.00	30,200.00	1.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,630,000.00	61,630,000.00	-	1.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,399,700.00	2,399,700.00	-	1.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	750,000.00	750,000.00	-	1.00
Газрын төлбөр	1,760,000.00	1,760,000.00	-	1.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300.00	300.00	-	1.00

Чойжин ламын сүм музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,050,200.00	3,020,000.00	30,200.00	0.99
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	-	-
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	-	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	-
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	270,163,800.00	268,732,901.00	1,430,899.00	0.99
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	231,353,800.00	225,441,901.00	5,911,899.00	0.97
Улсын төсвөөс санхүүжих	231,353,800.00	225,441,901.00	5,911,899.00	0.97
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	38,810,000.00	43,291,000.00	(4,481,000.00)	1.12
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,810,000.00	43,291,000.00	(4,481,000.00)	1.12
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	20.00	20.00	-	1.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	1.00
Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	-	1.00
Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	1.00
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>	-	1.00
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	15.00	15.00	-	1.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00	-	1.00

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>61,405,500.00</b>	<b>61,405,500.00</b>	<b>00.00</b>	100%
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>61,405,500.00</b>	<b>61,405,500.00</b>	<b>00.00</b>	100%
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	61,405,500.00	61,405,500.00	<b>00.00</b>	100%
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	10,343,695.00	10,343,695.00	<b>00.00</b>	100%
Урамшуулал	10,343,695.00	10,343,695.00	<b>00.00</b>	100%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,241,305.00	1,241,305.00	<b>00.00</b>	100%
Тэтгэврийн даатгал	827,537.00	827,537.00	<b>00.00</b>	100%
Тэтгэмжийн даатгал	103,442.00	103,442.00	<b>00.00</b>	100%
ҮОМШӨ-ний даатгал	82,754.00	82,754.00	<b>00.00</b>	100%
Ажилгүйдлийн даатгал	20,688.00	20,688.00	<b>00.00</b>	100%
Эрүүл мэндийн даатгал	206,884.00	206,884.00	<b>00.00</b>	100%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	928,800.00	928,800.00	<b>00.00</b>	100%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	928,800.00	928,800.00	<b>00.00</b>	100%
<b>Нормативт зардал</b>	2,760,000.00	2,760,000.00	<b>00.00</b>	100%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,760,000.00	2,760,000.00	<b>00.00</b>	100%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,167,200.00	16,167,200.00	<b>00.00</b>	100%
Багаж, техник, хэрэгсэл	14,749,300.00	14,749,300.00	<b>00.00</b>	100%
Тавилга	1,417,900.00	1,417,900.00	<b>00.00</b>	100%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	29,964,500.00	29,964,500.00	<b>00.00</b>	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,964,500.00	29,964,500.00	<b>00.00</b>	100%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	61405500.00	61405500.00	<b>00.00</b>	100%
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	61,405,500.00	61,405,500.00	<b>00.00</b>	100%
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,380,000.00	25,380,000.00	<b>00.00</b>	100%
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,025,500.00	36,025,500.00	<b>00.00</b>	100%
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>			<b>00.00</b>	0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			<b>00.00</b>	0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				0%

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Чойжин ламын сүм музей			Мянган төгрөгөөр	
				САГ-2019/27/СТА-ТШЗ	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Соёлын өвийн төвөөс 2017 онд 9 ширхэг Түүх соёлын дурсгалт зүйл хүлээн авсан. Үүнийг түүх соёлын дурсгалт зүйлээр бүртгэхдээ үнэлгээгүйгээр 0 төгрөгөөр бүртгэсэн байна.		Зөвлөмж өгсөн	Эрдэм шинжилгээ, сан хөмрөгийн нэгжийн дарга, Маркетингийн менежер, Нягтлан бодогч	М.Дарханчимэг Э.Баярзул, Д.Батжаргал
Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварыг 11 ажилтан, албан хаагчдаас 188.3 мянган төгрөг дутуу суутган авч тус дүнгээр гарт олгох цалинг илүү олгосон.	188.3	Зөвлөмж өгсөн		
Татварын тодорхойлолтод тайлант оны эцэст 675.4 мянган төгрөгийн өр төлбөр тусгагдсан байхад санхүүгийн тайланд 0 төгрөгөөр тусгагдсан.	675.4	Зөвлөмж өгсөн		
Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 20000 м2 газрыг 647,600.0 мянган төгрөгөөр дахин үнэлсэн боловч газрын гэрчилгээ сунгагдаагүй шалтгаанаар санхүүгийн тайланд тусгаагүй байна.	647,600.0	Албан шаардлага өгсөн		
<b>Зөвлөмжийн дүн</b>	<b>648,463.7</b>			

